



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХАРЬЯА
КООСЭН ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа
КООСЭН Технологийн коллежийн
дүрэм батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 02 сарын 07-ны өдрийн А/53 дугаар тушаалын хавсралт “Дээд боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм”, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа КООСЭН Технологийн коллежийн Удирдах зөвлөлийн дүрмийн 4.1.1, Удирдах зөвлөлийн 2024 оны 06 сарын 03-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- “ШУТИС-ийн харьяа Коосэн технологийн коллежийн дүрэм”-ийг хавсралтаар баталж, 2024 оны 06 дугаар сарын 03-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
- Батлагдсан дүрмийг мөрдөж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг ШУТИС-харьяа Коосэн технологийн коллежийн захирал (Д.Дулмаа), технологийн коллежийн сургуулийн бүтцийн нэгжүүдийн удирдлагуудад даалгасугай.





ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХАРЬЯА ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн харьяа Технологийн коллеж нь (цаашид ШУТИС-КООСЭН ТК гэх) нь бүрэн дундын боловсрол болон дээд боловсролын шаталсан сургалттай дэд бакалаврын зэрэг олгодог сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт, судалгаа, туршилт үйлдвэрлэлийн дээд боловсролын төрийн өмчийн байгууллага байна.
- 1.2. ШУТИС-КООСЭН ТК-ийн удирдлага, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, гадаад, дотоод харилцаа, хамтын ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай, Инновацын тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн акт, тэдгээртэй нийцүүлэн баталсан энэхүү ШУТИС-КООСЭН ТК-ийн дүрмээр зохицуулна.
- 1.3. ШУТИС-КООСЭН ТК-ийн хөгжлийн Алсын хараа:
“Азийн шилдэг, загвар технологийн коллеж болж, Монголын чадварлаг инженер залуусыг дэлхийд таниулна.”
- 1.4. ШУТИС-КООСЭН ТК-ийн Эрхэм зорилго:
“Инженерийн мэдлэг, ур чадвар өндөртэй, орчин үеийн технологийг эзэмшиж, улс эх орныхоо хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах, дэлхийн асуудлыг шийдвэрлэх, хүмүүнлэг иргэн инженерийг бэлтгэнэ.”
- 1.5. ШУТИС-КООСЭН ТК-ийн үнэт зүйлс: ШУТИС-КООСЭН ТК-ийн хамт олон (багш, судлаач, ажилтан, суралцагч, төгсөгч) бид эрхэм зорилгоо биелүүлэхийн тулд өөр өөрийн үүрэгт ажлаа гүйцэтгэхдээ, бүх төрлийн харилцаанд үүсэх дараах үнэт зүйлийг баритлан дагаж мөрднө.
- 1.6. ШУТИС-КООСЭН ТК-ийн үйл ажиллагааны зорилго нь Аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалын эрин үед Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа, судалгаа, инновацыг хөгжүүлэх, бүтээлч, олон соёлын орчинд ажиллах чадвартай, ёс суртахуунтай, хөрвөх ур чадвар бүхий инженерүүдийг бэлтгэхэд оршино.
- 1.7. ШУТИС-КООСЭН ТК-ийн оршин байгаа хаяг: “Монгол Улсын, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Бага тойруу 34, Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн 8 дугаар байр.”
- 1.8. ШУТИС-КООСЭН ТК-ийн оноосон нэрийг англи хэлээр “MUST-KOSEN College of Technology” гэх ба товчилсон нэр нь “MUST-KOSEN CT”, цахим хуудсын нэр нь “<http://www.kosentc.edu.mn>” байна.

- 1.9. “Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн харьяа ШУТИС-КООСЭН технологийн коллеж” нэрийн албан ёсны товчилсон нэр нь “ШУТИС-КООСЭН ТК” бөгөөд энэхүү товчлол нь Монгол улсын Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулиар тус технологийн коллежийн эзэмших барааны тэмдгээр баталгаажсан байна.
- 1.10. ШУТИС-КООСЭН ТК нь албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн туг, ёслолын хувцас, бэлэгдэл, дүрэмт болон дадлагын хувцастай байна.
- 1.11. ШУТИС-КООСЭН ТК-ийн Сургалт арга зүйн зөвлөл, холбогдох нэгж, зөвлөлүүд, энэхүү “ШУТИС-КООСЭН ТК-ийн дүрэм” болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн өөрийн дүрэм, журмыг баталж мөрдөнө.

Хоёр. ШУТИС-КООСЭН ТК-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэл

- 1.1. ШУТИС-КООСЭН ТК нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 1.1.1. Бүрэн дундын болон дээд боловсролын шаталсан сургалтын хөтөлбөр, суралцагчийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх, шинжлэх ухаан, технологи, инновац, сургуулийн үйл ажиллагааны чиглэлээр эрх бүхий этгээдийн баталсан бодлого, стратеги төлөвлөгөө, дүрэм, журмыг чанартай хэрэгжүүлэх, тайлagnaх.
- 1.1.2. Сургуулийн дотоод үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журмыг батлан хэрэгжүүлэх.
- 1.1.3. Бүрэн дундын болон дээд боловсролын шаталсан сургалт, түр сургалтын хөтөлбөр, агуулга, арга, хэлбэр, судалгаа, туршилтын ажлын зорилт, чиглэлийг тодорхойлж, чанартай хэрэгжүүлэх.
- 1.1.4. Зөвлөх үйлчилгээ, эрдэм шинжилгээ, судалгаа, хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх, оролцох.
- 1.1.5. Бүрэн дундын болон дээд боловсролын шаталсан сургалтын элсэлт, төгсөлтийн үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулах.
- 1.1.6. Тусгай хэрэгцээ шаардлагатай суралцагчийг дэмжих хөтөлбөр баталж, шаардагдах орчин нөхцөлийг бүрдүүлэх.
- 1.1.7. Технологийн коллежийн үйл ажиллагаа, сургалтад цахим технологи нэвтрүүлэх.
- 1.1.8. Гадаад, дотоодын боловсрол, шинжлэх ухааны байгууллага, шинжлэх ухааны парк, бусад этгээдтэй өөрийн эрх хэмжээний асуудлаар гэрээ, хэлэлцээр байгуулах, хамтран ажиллах.
- 1.1.9. Багш, ажилтан, суралцагчийг соён гэгээрүүлэх, олон нийтийн болон хүмүүнлэгийн чиглэлийн үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр батлан хэрэгжүүлэх.
- 1.1.10. Багш, ажилтан, суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, эрсдлээс урьдчилан сэргийлэх болон нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх.

- 1.1.11. Багш, ажилтны эрүүл мэндийг дэмжих зорилгоор хоёр жил тутам эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамруулах арга хэмжээг зохион байгуулах.
- 1.1.12. Амжилттай суралцаж, олон нийтийн болон хүмүүнлэгийн бүтээлч ажил гүйцэтгэсэн суралцагчид тэтгэлэг олгох, төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх.
- 1.1.13. Аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан сургалт, эрдэм шинжилгээний ажилд амжилт гаргасан суралцагчид нэрэмжит тэтгэлэг олгох, сургалтын төлбөр, амьжиргааны зардлын болон эрдэм шинжилгээ, судалгааны ажлын дэмжлэг үзүүлэх.
- 1.1.14. Багшаар ажиллах журам, багшийн мэргэжлийн хөгжлийг хангах, багш, ажилтны ажлын гүйцэтгэлийг дүгнэх журмыг тус тус баталж, хэрэгжүүлэх.
- 1.1.15. Сургууль жендерийн мэдрэмжтэй, хүний эрхийг эрхэмлэсэн, ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн хэрэгцээ, шаардлагыг хангасан сургалт, судалгааны орчин бүрдүүлэх.
- 1.1.16. Эрдэм шинжилгээ, инновациын үйл ажиллагаа эрхэлж, гарсан үр дүнг үйлдвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлэх.
- 1.1.17. Статистикийн болон бусад шаардлагатай мэдээллийг тогтоосон хугацаанд нь үнэн зөв гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх.
- 1.1.18. Хуульд заагдсан бусад чиг, үүрэг.
- 1.2. ШУТИС-КООСЭН ТК-ийн үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллээр суралцагч, багш, ажилтныг хангах, холбогдох мэдээллийг ил тод байлгах зохион байгуулалтын арга хэмжээ авах, технологийн коллежийн үйл ажиллагаа, үр дүнгийн талаар нээлттэй мэдээлэх тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.3. Багш, ажилтан, суралцагч интернэтийн орчинд ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлж, технологийн коллежийн цахим хуудастай байна. Технологийн коллежийн дотоод үйл ажиллагаандаа зориулан интернэт (дотоод сүлжээ)-тэй байна.
- 1.4. Багш, ажилтан, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас сургуулийн үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилт, багш, удирдах ажилтны мэргэжлийн чадавхи, ёс зүй, иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхолыг зөрчсөн хэмээн үзсэн гомдол, бусад асуудлаар хандсан өргөдөл, санал хүсэлтийг хууль тогтоомжид заасны дагуу хүлээн авч судлан хариу өгнө.
- 1.5. ШУТИС-КООСЭН ТК нь Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн хөдөлмөрийн харилцаа, дотоод үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан хөдөлмөрийн дотоод журамтай байх бөгөөд түүнийг холбогдох дүрэм, журмын дагуу баталж мөрдөнө.

Гурав. ШУТИС-КООСЭН ТК-ийн бүтэц, зохион байгуулалт

- 3.1. ШУТИС-КООСЭН ТК-ийн зохион байгуулалтын үндсэн нэгж нь тэнхим, лаборатори байна.
- 3.1.1. Тэнхим нь шинжлэх ухааны тодорхой салбараар төрөлжсөн, бүрэн дундын боловсрол болон дэд бакалаврын шаталсан цогц хөтөлбөрийг эрхлэн



хэрэгжүүлдэг, технологийн коллежийн хэмжээнд сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, олон нийтийн үйл ажиллагааг эрхлэх нэгж байна.

- 3.1.2. Лаборатори нь сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, туршилтын үйлчилгээ явуулахад зориулсан тоног төхөөрөмж, хүний нөөц бүхий сургалт, судалгааны орчин байна.
- 3.2. Тэнхим, лабораторийн бүтэц, зохион байгуулалт, ажиллах зарчим, үйл ажиллагааг холбогдох журмаар зохицуулна.
- 3.3. ШУТИС-КООСЭН ТК нь судалгааны лаборатори, төв, сургалт-үйлдвэрлэлийн дадлагын баазтай байна. ШУТИС-КООСЭН ТК нь эдгээр бүтцийн нэгжийг гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран зохион байгуулж, ажиллуулж болно.
- 3.4. ШУТИС-КООСЭН ТК нь оюуны болон технологийн нөөцийг ашиглах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ололтыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх зорилгоор өөрийн үндсэн бүтцэд “Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль”-ийн зорилтын хүрээнд технологи нэвтрүүлэх, дамжуулах төв, ажил олгогч, үйлдвэрлэлийн байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлж, суралцагчдын суралцах хугацаанд карьер хөгжлийг дэмжих карьерын хөгжлийн төв болон түүнтэй адилтгах нэгжийг бие даан, эсхүл хамтран байгуулж болно.
- 3.5. ШУТИС-КООСЭН ТК-ийн бүтэц, зохион байгуулалттай холбоотой асуудлыг дор дурдсанаар шийдвэрлэнэ. Үүнд:
- 3.5.1. ШУТИС-КООСЭН ТК-ийн Захиргааны бүтэц, зохион байгуулалт, тэнхим, төв, гарааны компани байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Шинжлэх ухаан технологийн хууль, ШУТИС-ийн дүрэм, журам болон бусад холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн ШУТИС-КООСЭН ТК-ийн Удирдах зөвлөл шийдвэрлэнэ.
- 3.6. ШУТИС-КООСЭН ТК-ийн бүтэц, зохион байгуулалтын нэгж, хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөөг Захирлын зөвлөлөөр хэлэлцүүлэн, холбогдох эрх бүхий албан тушаалтнаар батлуулна.
- 3.7. ШУТИС-КООСЭН ТК-ийн үйл ажиллагааны, санхүүгийн болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон болон Удирдах зөвлөлд тайлагнан, үнэлүүлнэ.

Дөрөв. ШУТИС-КООСЭН ТК-ийн удирдлага

- 4.1. ШУТИС-КООСЭН ТК-ийн өөрийн удирдлагыг Удирдах зөвлөл, захиргааны удирдлагыг Захирлын зөвлөл, мэргэжил, арга зүйн удирдлагыг Сургалт, арга зүйн зөвлөл тус тус хэрэгжүүлнэ.
- 4.2. Удирдах зөвлөл нь Дээд боловсролын тухай хуульд заасны дагуу байгуулагдаж, үйл ажиллагаагаа ШУТИС-КООСЭН ТК-ийн Удирдах зөвлөлийн дүрмээр зохицуулна. Дүрмийг Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж, батална.
- 4.3. ШУТИС-КООСЭН ТК-ийн Сургалт, арга зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Захирлын тушаалаар батална.
- 4.4. Сургалт, арга зүйн зөвлөл нь сургалт, эрдэм шинжилгээний бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байна.

- 4.5. Сургалт, арга зүйн зөвлөлд ШУТИС, Японы технологийн коллежийн тухайн мэргэжлийн мэргэшсэн багш, профессор, судлаач нарыг урьж ажиллуулж болно.
- 4.6. ШУТИС-КООСЭН ТК-ийн Сургалт, арга зүйн зөвлөл нь доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 4.6.1. Сургалт, судалгааны ажлын үндсэн чиглэлийг тогтоох, хэрэгжилтийн үр дүнг хэлэлцэх, дүгнэлт гаргах.
 - 4.6.2. Сургалт, судалгаа, инновациын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үр дүнг хэлэлцэх, үнэлэлт дүгнэлт өгөх.
 - 4.6.3. Дэд профессор, профессор, хүндэт цол олгох саналыг ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлд уламжлах.
 - 4.6.4. сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэлэлцүүлэх, хэрэгжүүлэх, сайжруулах зорилгоор
 - 4.6.5. сургалтын хөтөлбөрийг · боловсруулах, хэлэлцүүлэх, хэрэгжүүлэх, сайжруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байна.
 - 4.6.6. сургалт арга зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Захирлын тушаалаар батална.
 - 4.6.7. сургалт арга зүйн зөвлөлийг Сургалтын албаны дарга удирдан зохион байгуулна.
 - 4.6.8. сургалт арга зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнд тэнхимиин эрхлэгч, багшаас гадна ажил олгогчийн төлөөлөл, ШУТИС болон Японы технологийн коллежийн багш, судлаач, мэргэжилтэнг урьж ажиллуулж болно.
- 4.7. Сургалт, арга зүйн зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдсон бусад харилцааг ШУТИС-КООСЭН ТК-ийн Сургалт, арга зүйн зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах дүрмээр зохицуулна.
- 4.8. ШУТИС-КООСЭН ТК-ийн гүйцэтгэх удирдлагыг Захирал (цаашид “гүйцэтгэх удирдлага” гэх) хэрэгжүүлнэ.
- 4.9. ШУТИС-КООСЭН ТК-ийн Захирал нь Монгол улсын хууль, тогтоомж, энэхүү дүрэм, ШУТИС-КООСЭН ТК-ийн удирдах зөвлөлийн даргатай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлнэ.
- 4.10.ШУТИС-КООСЭН ТК-ийн Захирал нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:
- 4.10.1. Технологийн коллежийг улсын хөгжлийн бодлоготой уялдуулан хөгжүүлэх стратеги төлөвлөгөө, чиглэл, хөтөлбөрийг санаачлан Удирдах зөвлөлөөр батлуулж, хэрэгжилтийг хангах.
 - 4.10.2. ШУТИС-КООСЭН ТК-ийн бүтэц, зохион байгуулалтын саналыг боловсруулан Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.
 - 4.10.3. Технологийн коллежийн бүтцийн үндсэн нэгжүүдийг хэвийн тогтвортой ажиллах нэгдсэн зохицуулалт, удирдлагаар хангах, үр дүнг хариуцах.
 - 4.10.4. Гадаад, дотоод хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, хамтарсан сургалт, хөтөлбөр, эрдэм шинжилгээ, судалгааны төсөл хэрэгжүүлэх асуудлаар гэрээ, хэлэлцээр байгуулах, хэрэгжилтийг хангах.
 - 4.10.5. Байгууллагын стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшний хэрэгжилтийн чанар, үр дүнг бүрэн хариуцах.

- 4.10.6. Санхүүжилт, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бүрдүүлж, санхүү, төсвийг үр дүнтэй төлөвлөж зарцуулах.
- 4.10.7. Технологийн коллежийн хөгжлийг дэмжихэд үр нөлөөтэй, хөгжихүйн болон чадахуйн /мерит/ зарчмыг хангасан засаглал, менежментийн тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлэх.
- 4.10.8. Хүний нөөцийг чадавхжуулах, өндөр мэдлэг үр чадвартай мэргэжилтнийг татан ажиллуулах нөхцлийг бүрдүүлсэн хүний нөөцийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж, багш, ажилтны нийгмийн баталгааг хангах.
- 4.10.9. Технологийн коллежийн чанарын удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.
- 4.10.10. Багш, судлаач, эрдэм шинжилгээний ажилтан болон бусад ажилтны орон тоо, цалингийн сүлжээг батлах.
- 4.10.11. Багш, ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг батлах.
- 4.10.12. Хүний нөөцийн сонгон шалгаруулалтыг чадахуйн /мерит/ болон хөгжихүйн зарчимд үндэслэн явуулж, томилох, чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээ байгуулах, биелэлтийг дүгнэх, цуцлах, чөлөө олгох, сахилгын шийтгэл ногдуулах, шагнал урамшуулал олгох, тодорхойлох.
- 4.10.13. Нийт багш, ажилчидтай жил бүр үр дүнгийн гэрээ байгуулах, тайланг хэлэлцүүлэх, үнэлэлт дүгнэлт өгөх.
- 4.10.14. Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн ШУТИС-КООСЭН ТК-д мөрдөх дүрэм, журмуудыг батлах, мөрдүүлэх.
- 4.10.15. Албан тушаалын бүрэн эрхийнхээ хүрээнд хамаарах асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргах.
- 4.10.16. Үйл ажиллагааны үр дүнгийн талаар Удирдах зөвлөл, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тайлагнах.
- 4.10.17. Зарим эрх үүргээ түр хугацаагаар холбогдох албан тушаалтанд шилжүүлэх, итгэмжлэх.
- 4.10.18. ШУТИС-КООСЭН ТК-ийн Сургалт, арга зүйн зөвлөл, Захирлын зөвлөлийн бүрэлдэхүүнийг хянан батлах.
- 4.10.19. ШУТИС-КООСЭН ТК-ийн Сургалт, арга зүйн зөвлөл, Захирлын зөвлөлийг удирдах.
- 4.10.20. Тодорхой асуудлаар ажлын хэсэг байгуулах.
- 4.10.21. Удирдах зөвлөлийг хуралдуулах саналыг Удирдах зөвлөлийн даргад тавих.
- 4.10.22. Хууль тогтоомжид заасан бусад эрхийг эдэлж, үүргийг биелүүлэх.
- 4.11. ШУТИС-КООСЭН ТК-ийн захирал нь эрхэлсэн ажил, үйл ажиллагаагаа үр нөлөөтэй, тасралтгүй, хэвийн жигд явуулах орчин нөхцөл бүрдүүлэх, бодлогын хэрэгжилтийг хангах зорилго бүхий алба, нэгж, тэнхимтэй байна. Эдгээрийн чиг үүрэг, орон тоог захирал батална.
- 4.12. ШУТИС-КООСЭН ТК-ийн Захирал нь албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улс төр, эдийн засаг, шашны аливаа нөлөөлөлд орохгүй, багш, ажилчид, суралцагчдын эрх ашгийг эрхэмлэн ажиллана.



- 4.13. ШУТИС-КООСЭН ТК нь тодорхой чиг үүрэг, үйл ажиллагаа эрхэлсэн сургалтын албаны дарга, нийгмийн ажилтан, менежер, гадаад харилцаа, хамтын ажиллагааны алба, тэнхимиийн эрхлэгч болон бусад нэгжийн удирдах албан тушаалтантай байна. Нэгжийн удирдах албан тушаалтнууд нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний захиргааны, сургалт, судалгаа, суралцагч хөгжлийн нэгжүүдийн өдөр тутмын ажлыг шууд удирдлагаар хангаж ажиллана.
- 4.14. Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалд тавигдах шаардлагыг үндэслэн ШУТИС-КООСЭН ТК-ийн нэгжийн удирдах албан тушаалтанд тухайн албан тушаалд Захирлын тушаалаар томилно.
- 4.15. ШУТИС-КООСЭН ТК-ийн Захирал түр хугацаагаар эзгүй байх үедээ өөрийн албан үүргийг аль нэг нэгжийн удирдах албан тушаалтанд орлуулан гүйцэтгүүлнэ.
- 4.16. ШУТИС-КООСЭН ТК-ийн нэгжийн удирдах албан тушаалтны албан үүргийг түр орлон гүйцэтгэх, хавсрсан ажиллуулах асуудлыг журмаар зохицуулна.
- 4.17. ШУТИС-КООСЭН ТК-ийн Захирлын зөвлөл нь ШУТИС-КООСЭН ТК-ийн хамтын удирдлагын зарчмыг хэрэгжүүлэн захиргааны удирдлагаар хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, Удирдах зөвлөлд уламжлах чиг үүрэгтэй ажиллана.
- 4.18. ШУТИС-КООСЭН ТК-ийн Захирлын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам, дэгийг Захирлын тушаалаар батлана. Захирлын зөвлөлийн бүрэлдэхүүнд ШУТИС-КООСЭН ТК-ийн нэгжийн удирдах албан тушаалтнууд, тодорхой чиг үүрэг бүхий захиргааны зарим нэгжийн ажилтан ажиллана.
- 4.19. ШУТИС-КООСЭН ТК-ийн Захирлын зөвлөл нь дараах чиг үүрэгтэй ажиллана.
- 4.19.1. ШУТИС-КООСЭН ТК-ийн үйл ажиллагаа, хөгжлийн талаар бодлого, хөтөлбөрийг хэлэлцэх, хэрэгжүүлэх.
- 4.19.2. Үйл ажиллагааг зохицуулах журам, дэг, заавруудыг хэлэлцэх, батлах нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэгжилтэд хяналт тавих.
- 4.19.3. ШУТИС-КООСЭН ТК-ийн Удирдах зөвлөл, Сургалт, арга зүйн зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих.
- 4.19.4. ШУТИС-КООСЭН ТК-ийн төвлөрсөн санг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт, төсвийн зарцуулалтын асуудлыг хэлэлцэх, хэрэгжүүлэх.
- 4.19.5. Мэргэжилтэн бэлтгэх сургалт болон ур чадвар сайжруулах түр сургалтын хөтөлбөрийг хэлэлцэх.
- 4.19.6. ШУТИС-КООСЭН ТК-ийн Удирдах зөвлөл, Сургалт, заах арга зүйн зөвлөл болон төрийн захиргааны холбогдох дээд байгууллагад тавих, хэлэлцүүлэх аливаа асуудлыг хэлэлцэж, Удирдах зөвлөлд санал хүргүүлэх.
- 4.19.7. Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр болоод хүний нөөцтэй холбогдолтой бусад асуудлыг хэлэлцэх.
- 4.19.8. Байгууллагын алба, нэгж, тэнхимиийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, хяналт, шалгалт, аудитын тайланг хэлэлцэх, холбогдох дүгнэлт, шийдвэрийг гаргах.



Тав. ШУТИС-КООСЭН ТК-ийн сургалт, судалгааны үйл ажиллагаа

- 5.1. ШУТИС-КООСЭН ТК-ийн хэмжээнд үйлчлэх сургалт, түр сургалт, судалгааны үйл ажиллагааг зохицуулах журмыг нийтээр мөрдөн ажиллана.
- 5.2. ШУТИС-КООСЭН ТК-д сургалт, судалгаа, инновацын үйл ажиллагааг зохицуулах тусгайлсан журмыг холбогдох ШУТИС-ийн проректортой зөвшилцсөний үндсэн дээр боловсруулан хэлэлцүүлж, ШУТИС-КООСЭН ТК-ийн Захирал батална.
- 5.3. ШУТИС-КООСЭН ТК нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон сургалт эрхлэх тусгай болон энгийн зөвшөөрлийн дагуу сургалтыг зохион байгуулна.
- 5.4. Суралцагч элсүүлэх үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 26.1.22 дугаар зүйл, Дээд боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйл болон бусад холбогдох журмыг баримтлан зохион байгуулна.
- 5.5. Сургалтын үйл ажиллагааг Дээд боловсролын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу зохион байгуулна.
- 5.6. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Дээд боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйл болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан холбогдох дүрэм, журмыг баримтална.
- 5.7. Сургалт арга зүйн зөвлөл нь сургалтын хөтөлбөр, хичээлийн стандартыг боловсруулж, ШУТИС-ийн Хөтөлбөрийн ерөнхий хороогоор хэлэлцүүлж дүгнэлтийг тусгана.
- 5.8. Сургалт, арга зүйн зөвлөл нь ШУТИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хорооны саналыг үндэслэн сургалтын хөтөлбөрийг хэлэлцэж, шийдвэрийг сургуулийн гүйцэтгэх удирдлагад хүргэж батлуулна.
- 5.9. Хөтөлбөрийн дэд хороо нь батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу хичээлийн хуваарь, төлөвлөгөө, дадлагын хөтөлбөрийг боловсруулах.
- 5.10. Сургалтын үйл ажиллагааг сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, хичээлийн стандарт, хичээлийн хуваарийн дагуу зохион байгуулна.
- 5.11. ШУТИС-КООСЭН ТК-ийн бэлтгэн гаргаж буй сургалтын хөтөлбөр, мэргэжлийн чиглэлийн хүрээнд ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиас мэргэшсэн профессор, багш, судлаачдаас бүрдсэн профессорын багийг ажиллуулж болно.
- 5.12. ШУТИС-КООСЭН ТК нь төгсөгчиддөө боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу диплом олгоно.
- 5.13. Технологийн коллежийн хэмжээнд судалгааны үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Дээд боловсролын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль болон холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн актыг баримталж ажиллана.
- 5.14. Технологийн коллежийн судалгааны тэргүүлэх чиглэлээр судалгааны ажлыг дэмжиж тухайн сургуулийн судалгааны баг, багш, суралцагчдад санхүүжилт олгож болно.

Зургаа. Хүний нөөц

- 6.1. Багш, ажилтны хөдөлмөрийн харилцааг Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Боловсролын тухай багц хуулиуд, ШУТИС-КООСЭН ТК-ийн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, холбогдох бусад хууль, эрх зүйн актаар зохицуулна.
- 6.2. Багш нь Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйл, Дээд боловсролын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан эрх, үүрэгтэй байна.
- 6.3. Багш, ажилтан Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлд заагдсан нийгмийн баталгаагаар хангагдана.
- 6.4. Багш, ажилтны албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн сүлжээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, ШУТИС-КООСЭН ТК-ийн Захирлын тушаалаар батална.
- 6.5. Багш нь тухайн албан тушаалын тодорхойполтод хамаарах ажил үүргийг гүйцэтгэх удирдлага буюу түүний эрх олгосон этгээдтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ. Уг гэрээнд тухайн ажил үүргийг гүйцэтгэхэд шаардагдах нөхцөл, ажлын цаг, олгох цалин хөлс, давхар, нэмэлт болон сургуулиас гадуур ажил эрхлэх зохицуулалт, хариуцах эд хөрөнгө, хүлээх хариуцлага, тусгай шаардлага, ёс зүйн хэм хэмжээ зэргийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тодорхой тусгасан байна.
- 6.6. Хууль тогтоомжинд нийцүүлэн гүйцэтгэх удирдлагын баталсан холбогдох журмын дагуу багш, ажилтныг сонгон шалгаруулах, томилох, чөлөөлөх үйл ажиллагааг зохион байгуулна.
- 6.7. ШУТИС-КООСЭН ТК-ийн багш нь тухайн салбараар мэргэшсэн, тодорхой чиглэлээр судалгаа явуулдаг, дээд боловсролын салбарт багшлах бол магистр ба түүнээс дээш зэрэгтэй байна. Семинар, дадлага, лабораторийн хичээлийг тухайн мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн, зөвлөх, дадлага, туршлагатай мэргэжилтэн удирдаж болно.
- 6.8. Багш, ажилтнууд нь сургалт, судалгаа шинжилгээ, үйлчилгээний ажлыг хэвийн явуулах нөхцөлөөр хангагдсан байх ба харилцааны соёл, ёс суртахуун, мэргэжлийн өндөр ур чадвартай, мэдлэг боловсролоороо манлайлагч байна.
- 6.9. ШУТИС-КООСЭН ТК нь багшийн мэргэжлийн хөгжлийг хангах хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлнэ.
- 6.10. Багш, ажилтны гүйцэтгэх үүрэг, сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, олон нийтэд үйлчлэх ажлын ачаалал, түүнийг тооцох журмыг ШУТИС-КООСЭН ТК-ийн Захирлын тушаалаар батална.
- 6.11. Тэнхимд болон бусад алба нэгжид гадаадын зочин профессор, мэргэжилтэнг ажиллуулж болох бөгөөд албан тушаалын зэрэглэл, ажлын ачаалллыг Захирлын тушаалаар тогтооно.
- 6.12. Тэнхим болон бусад алба, нэгжийн саналыг үндэслэн, хүний нөөцийн эрдэм шинжилгээ, судалгааны чадавхыг нэмэгдүүлэх, багш наарт мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, мэргэжлийн хичээл орох, мэргэжлийн ном, сурх бичиг бичих, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зөвлөгч ба гүйцэтгэгчээр оролцуулах, гадаад дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор



тэнхим болон бусад алба, нэгжид иргэнийг хөлсөөр ажиллуулах гэрээгээр Зөвлөх профессор, мэргэжилтнээр ажиллуулж болно.

- 6.13. ШУТИС-КООСЭН ТК нь багш, ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх, үр дүнгийн гэрээг үнэлж дүгнэх журамтай байна. Энэхүү журамд багш, ажилтны ажлыг дүгнэх гүйцэтгэлийн шалгуур, үзүүлэлтүүд, дүгнэх хугацаа, зохион байгуулалтыг тодорхой тусгасан байна.

Долоо. ШУТИС-КООСЭН ТК-ийн суралцагч

- 7.1. Суралцагч Боловсролын ерөнхий хуулийн 10 дугаар зүйл, Дээд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
- 7.2. Сургууль, суралцагчийн харилцааг сургууль, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч нарын хоорондын гурвалсан суралцах эрхийн гэрээ, сургуулийн дүрэм, дотоод журмаар зохицуулна. Суралцагч болон түүний эцэг, эх, асран хамгаалагч нь суралцах эрхийн гурвалсан гэрээг ШУТИС-КООСЭН ТК-ийн Сургалтын албаны даргатай байгуулж, Захирлаар баталгаажуулах ба гэрээнд заагдсан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
- 7.3. Суралцагчдын элсэх, суралцах, шатлан суралцах, төгсөхөд тавигдах шаардлага, эдгээр үйл ажиллагааны харилцааг холбогдох дүрэм, журмаар зохицуулна.
- 7.4. Суралцагч нь сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд заасан сургалтын бүх хэлбэрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, хөтөлбөрт заасан хичээлүүдийг судлах, тогтоосон хугацаанд шалгалт өгч сургалтын бусад даалгаврыг гүйцэтгэх үүрэгтэй.
- 7.5. Суралцагч болон эцэг, эх, асран хамгаалагч нь сургалтын төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх үүрэгтэй.
- 7.6. Суралцагч нь оюутны зөвлөл болон бусад төлөөллийн байгууллагаараа дамжуулан технологийн коллежийн шийдвэр гаргах үйл явцад оролцох, санал бодлоо илэрхийлэх замаар нийтлэг эрх ашгаа хамгаалуулах эрхтэй.
- 7.7. Суралцагч нь суралцах, судалгааны ажил хийх таатай боломж нөхцөлөөр хангагдах, өөрийгөө хөгжүүлэх, нийгэм, соёлын үйлчилгээ авах эрхтэй.
- 7.8. Суралцагчид нь технологийн коллежид баримталж буй хууль, дүрэм журмыг дээдлэн, багш, шавийн харилцааг хүндэтгэх ба суралцах чин эрмэлзэл, бүтээлч санаачлага, харилцааны соёл, ёс суртахуунтай байна.

Найм. ШУТИС-КООСЭН ТК-ийн багш, ажилтан, суралцагч, төгсөгч, дэмжигч, эцэг, эх, асран хамгаалагчийн сайн дурын байгууллага, зөвлөл

- 8.1. ШУТИС-КООСЭН ТК-ийн багш, ажилтан, оюутан суралцагч, төгсөгч, дэмжигч, эцэг эх, асран хамгаалагчийн хууль ёсны эрх, ашиг, сонирхлыг хамгаалах, сургуулийн хөгжлийг дэмжих, хамтран ажиллах зорилго бүхий ШУТИС-КООСЭН ТК-ийн багш, ажилтан, оюутан, төгсөгч, дэмжигч, эцэг, эх, асран хамгаалагчийн сайн дурын байгууллага, зөвлөлийг харьяалах хүмүүсийн санаачлагаар зохион байгуулан ажиллуулж болно.

- 8.2. ШУТИС-КООСЭН ТК-ийн багш, ажилтан, оюутан, төгсөгч, дэмжигч, эцэг эх, асран хамгаалагчийн сайн дурын байгууллага, зөвлөлийн тэргүүн, даргыг тухайн байгууллагын дүрмийн дагуу сонгоно.
- 8.3. ШУТИС-КООСЭН ТК-ийн багш, ажилтан, оюутан, төгсөгч, дэмжигч, эцэг эх, асран хамгаалагчийн сайн дурын байгууллага, зөвлөл нь Монгол улсын холбогдох хууль, тогтоомж, ШУТИС-КООСЭН ТК-ийн дүрэм, журмын хүрээнд үйл ажиллагаа явуулна.
- 8.4. ШУТИС-КООСЭН ТК-д оюутан суралцагчдын эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн үйл ажиллагаа, соёл, олон нийтийн арга хэмжээ, зохион байгуулах үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн оюутны байгууллага өөрийн удирдлагын зарчимд тулгуурлан ажиллаж болно.
- 8.5. ШУТИС-КООСЭН ТК-ийн оюутны байгууллага нь зөвхөн ШУТИС-КООСЭН ТК-ийн оюутан, суралцагчдын төлөөллөөс бүрдэх ба хууль тогтоомжид нийцсэн үйл ажиллагааны дүрмийг батлан мөрдөнө.
- 8.6. ШУТИС-КООСЭН ТК-ийн багш, ажилтан, оюутан, төгсөгч, дэмжигч, эцэг эх, асран хамгаалагчийн сайн дурын байгууллага, зөвлөл нь технологийн коллежийн үйл ажиллагааны зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, холбогдох үйл ажиллагаанд нь санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

Ес. Санхүүжилт

- 9.1. ШУТИС-КООСЭН ТК-ийн санхүүгийн үйл ажиллагааг Боловсролын тухай хуулийн 37, 38 дугаар зүйл, Дээд боловсролын тухай хуулийн 32, 33 дугаар зүйл, бусад холбогдох хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан санхүү, нягтлан бodoх бүртгэлийн бодлого, санхүүгийн дүрэм, журмыг баримтлан хэрэгжүүлнэ.
- 9.2. ШУТИС-КООСЭН ТК нь улсын төсвийн болон технологийн коллежийн үйл ажиллагаанаас оруулсан хөрөнгийг үүсгэн байгуулагчтай байгуулсан гэрээ, Удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу үр ашигтай зарцуулах үүрэгтэй.
- 9.3. Санхүүгийн олон талт эх үүсвэрээ нэмэгдүүлэх, инновац, гарааны бизнесийг хөгжүүлэх, багш, ажилтан, суралцагчдын нийгмийн баталгааг дээшлүүлэх зорилгоор хууль тогтоомжид нийцүүлэн явуулсан аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлогоо Боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Инновацын тухай хууль болон бусад холбогдох хууль, журамд заасны дагуу захиран зарцуулна.
- 9.4. ШУТИС-КООСЭН ТК-ийн санхүүжилт нь Боловсролын тухай хуулийн 37, 38 дугаар зүйл, Дээд боловсролын тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ.
- 9.5. Тухайн жилийн батлагдсан төсөвт хөрөнгийн бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалтад хяналт тавих ажлыг холбогдох чиг үүрэг бүхий албан тушаалтан хариуцна.
- 9.6. ШУТИС-КООСЭН ТК-ийн дараа оны орлого, зарлагын төсвийг өмнөх оны 12 дугаар сарын 15-ны дотор Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулна.
- 9.7. ШУТИС-КООСЭН ТК нь жилийн тайлан, дараа жилийн тайлан, балансыг санхүүгийн асуудал эрхэлсэн нэгжид дараа жилийн 02 дугаар сарын 10-ны дотор багтаан хүргүүлнэ.



- 9.8. ШУТИС-КООСЭН ТК нь хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг Төсвийн тухай хууль, санхүүгийн холбогдох журамд заасан хугацаанд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад дээд байгууллагуудад хүргүүлнэ.
- 9.9. ШУТИС-КООСЭН ТК нь Боловсролын ерөнхий хуульд заасны дагуу санхүүгийн үйл ажиллагааг зохион байгуулан Удирдах зөвлөлд тайлагнана.

Арван. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах ба хүчин төгөлдөр болох

- 10.1. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Удирдах зөвлөл, Сургалт, арга зүйн зөвлөл болон ШУТИС-КООСЭН ТК-ийн Захирлын зөвлөлийн гишүүд, багш, оюутны төлөөллийн байгууллага гаргаж болно.
- 10.2. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж батлах бөгөөд баталсан тухай шийдвэр гарснаар хүчин төгөлдөр болно.

--ООо--